



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Статистикийн танилцуулга

2017/9



АГУУЛГА

Хуудасны

дугаар

	ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2017 ОН	4
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	5
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	8
	АЖ ҮЙЛДВЭР	11
	ХӨДӨӨ АЖ АХУЙ	13
	БАРИЛГА	14
	ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	14
	МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО	14
	НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	15
	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	15
	НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	16
	ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	18
	ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	19
	ГЭМТ ХЭРЭГ	21
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	22

ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Жил бүрийн эхний 9 сарын байдлаар


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	141252	153859	162196
Шинээр төрсөн хүүхэд	тоо	3329	3428	3243
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	1512	970	555
Үүнээс: эмэгтэй	хүн	811	526	324
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	2756	2880	1875
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	1047	1271	1275
Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	-0.9	-0.9	0.5
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1996.8	2287.3	2464.4
Дүүргийн төсвийн орлого	сая.төг	34490.5	38799.6	40262.6
Дүүргийн төсвийн зарлага	сая.төг	29713.6	32935.6	34074.1



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 9-р сарын Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2016 оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар, 2016 оны эцэстэй харьцуулахад 6.6 хувиар, өмнөх сартай харьцуулахад 0.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, 2015-2017 он



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2017 оны 9-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 6.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 2.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 7.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 4.3 хувь, тээврийн үйлчилгээ 10.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 2.3 хувь, боловсролын үйлчилгээ 7.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 1.3 хувь, бусад бараа, үйлчилгээ 4.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2016-09</u> 2015-09	<u>2017-09</u> 2016-09	<u>2017-09</u> 2016-12	<u>2017-09</u> 2017-08
Ерөнхий индекс	99.3	106.6	106.6	100.5
Хүнсний бараа, ундаа, ус	96.6	109.2	111.0	99.3
Согтууруулах ундаа, тамхи	104.4	101.9	102.1	100.0
Хувцас, бөс бараа, гутал	99.4	103.8	102.9	101.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	98.4	110.9	107.1	102.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.4	101.3	101.7	100.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.1	105.2	104.3	100.1
Тээвэр	98.5	110.4	110.1	100.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.7	100.5	100.5	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.9	100.0	102.3	100.0
Боловсролын үйлчилгээ	102.6	107.4	107.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	100.9	101.9	101.3	101.6
Бусад бараа, үйлчилгээ	100.3	105.4	104.5	100.2

2017 оны 9-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 23.0 хувийнх нь үнэ өсч, 12.8 хувийнх нь үнэ буурч, 64.2 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.7	Энэ бүлгийн бууралтад мах, махан бүтээгдэхүүн 2.0 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн 0.1 хувиар, хүнсний ногоо 2.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.
Хувцас, бөс бараа, гутал	1.6	Энэ бүлгийн өсөлтөд хөвөн, бөс бараа 2.0 хувиар, бүх төрлийн хувцас 1.8 хувиар, бүх төрлийн гутал 1.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	2.6	Энэ бүлгийн өсөлтөд хатуу түлш 8.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.2	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн өсөлтөд гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.4 хувиар, гэр ахуйн жижиг багаж хэрэгсэл 0.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.1	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 0.1 хувиар өссөнтэй холбоотой байв.
Тээвэр	0.7	Тээврийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь автомашин, мотоцикл 2.1 хувиар, агаарын зорчигч тээврийн үйлчилгээ 2.3 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	1.6	Энэ бүлгийн өсөлтөд гуанз, цайны газрын үйлчилгээ 3.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.2	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 0.3 хувиар, хувь хүний бусад эд зүйлс 0.3 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Эх үүсвэр: “Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал” статистикийн 2017 оны 9-р сарын танилцуулга

2017 оны 9-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Элсэн чихэр 400 төгрөг, төмс 250 төгрөг, цагаан будаа 100 төгрөг, задгай сүү 300 төгрөг, “Сүү” ХК-ны цөцгийтэй тараг 630 төгрөгөөр тус тус өссөн байхад хонины мах 500 төгрөг, үхрийн мах 600 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 250 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 50 төгрөг, байцаа 300 төгрөг, лууван 200 төгрөг, манжин 300 төгрөг,


сонгино 100 төгрөг, фүжи алим 600 төгрөгөөр буурсан байна. Харин “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил, “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 3. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, жил бүрийн 9-р сарын байдлаар


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2016.09	2017.09	$\frac{2017}{2016} \%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1160	1160	100.0
Хонины мах, ястай	Кг	4700	4200	89.4
Үхрийн мах, ястай	Кг	6900	6300	91.3
Гурил, дээд зэрэг, “Алтан тариа”	Кг	1700	1450	85.3
Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1170	1120	95.7
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	900	900	100.0
Элсэн чихэр	Кг	1900	2300	121.1
Төмс, монгол	Кг	600	850	141.7
Байцаа, монгол	Кг	1500	1200	80.0
Лууван, монгол	Кг	1200	1000	83.3
Манжин, монгол	Кг	1800	1500	83.3
Сонгино, хятад	Кг	1600	1500	93.8
Цагаан будаа	Кг	2300	2400	104.3
Алим, фүжи	Кг	4500	3900	86.7
Сүү, задгай	литр	1200	1500	125.0
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	1900	2530	133.2

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 2. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг




Зураг 3. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 4. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 5. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 4. Нэг литр шатахууны үнэ, 2017.09.28-ны байдлаар, төгрөг

ШТС	2016.08.31					2017.08.31				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1750	1470	1530	1640		1820		1630	1720	
Петровис	1750	1470	1530	1640		1820	1480	1630	1720	
Магнай трейд	1750	1470	1530	1640		1820	1480	1630	1720	
Сод монгол	1750		1530	1640		1820		1630		
Шунхлай		1450	1530	1640				1630	1720	
Юнигаз					900					1050
Дундаж үнэ	1750	1460	1530	1640	900	1820	1480	1630	1720	1050


Эх үүсвэр: "Нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал" статистикийн 2017 оны 9-р сарын танилцуулга



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2017 оны эхний 9 сард дүүргийн орон нутгийн төсвийн орлого 40.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 579.4 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар тасарсан байна.

Зураг 6. Төсвийн орлого, зарлага, 2011-2017 он, сая төг



Төсвийн нийт орлогын 31.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 6.0 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 62.2 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Хүснэгт 5. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны эхний 9 сард сая.төг

Төсвийн орлого			Үүнээс:									
Бүгд	ТБ %	Зөрүү сая. төг	Татварын орлого			Татварын бус орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	
Дүн	40262.6	98.6	-579.4	12830.2	92.2	-1086.0	2396.8	127.0	509.2	25035.7	-2.6	100.0

Татварын орлогын хэмжээ 12.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1086.0 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар тасарсан байна. Харин татварын бус орлого 2.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 509.2 сая төгрөгөөр буюу 27.0 хувиар давж биелэсэн байна.


Бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 1.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 0.4 сая төгрөгөөр тус тус тасарсан бол орлогын албан татвар төлөвлөснөөс 837.4 сая төгрөгөөр илүү бүрджээ.

Татварын бус орлогын 74.7 хувийг торгуулийн орлого, 25.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого болон бусад орлого, татварын орлогын 58.8 хувийг орлогын албан татвар, 41.2 хувийг хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж тус тус эзэлж байна.

Зураг 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Татварын бус орлогын бүтэц, хувиар



2017 оны эхний 9 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 90.6 хувийг буюу 34.1 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 9.4 хувийг буюу 3.5 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Хүснэгт 6. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны эхний 9 сард сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ, %	Зөрүү
Орон нутгийн орлого	40842.0	40262.6	98.6	-579.4
1.Татварын орлогын дүн	13916.2	12830.2	92.2	-1086.0
1.1 Орлогын албан татвар	6709.7	7547.1	112.5	837.4
Хувь хүний орлогын албан татвар	6709.7	7547.1	112.5	837.4
1.2 Хөрөнгийн албан татвар	26.7	27.1	101.5	0.4
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	7179.8	5256.0	73.2	-1923.8
Улсын тэмдэгтийн хураамж	5926.8	3733.1	63.0	-2193.7
Ашигт малтмал ашигласны төлбөр	78.0	45.6	58.4	-32.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1175.0	1477.3	125.7	302.3
2.Татварын бус орлогын дүн	1887.5	2396.8	127.0	509.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого	745.3	550.6	73.9	-194.7
Торгуулийн орлого	1082.2	1791.3	165.5	709.1
Бусад орлого	60.0	54.9	91.5	-5.1
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	25038.3	25035.7	100.0	-2.6
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	24849.9	24865.5	100.1	15.6
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	188.4	170.2	90.3	-18.2

Төсвийн нийт зарлагын 45.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 5.1 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 5.7 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 43.3 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2017 оны эхний 9 сард сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	40262.6	37611.6	34074.1	90.6	3537.5	6188.5

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 127.3 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 111.9 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, 63.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, сарын эцэст нийт 175.9 сая төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 8. Өглөг, 2017 оны эхний 9 сард, сая.төг


	9-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	9-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	127.3	111.9	63.3	175.9



АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 9 сард 654.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 610.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 10.4 хувиар, борлуулалт 19.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2016-2017 оны сар бүрээр, тэрбум төгрөг



Хүснэгт 9. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр

/оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2016 он I-IX сар	2017 он I-IX сар	$\frac{2017}{2016} \%$
Уул уурхай олборлох үйлдвэр	13805.7	15384.7	111.4
Төмрийн хүдэр олборлолт	13208.5	14580.7	110.4
Бусад ашигт малтмал олборлолт	597.2	804.0	134.6
Боловсруулах үйлдвэр	505864.2	562187.8	111.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	260188.7	245345.1	94.3
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	3125.4	1452.9	46.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1660.1	12013.4	7.2*
Хүнсний бусад бүтээгдэхүүн	18786.1	24732.8	131.7
Ундаа үйлдвэрлэл	236617.1	207146.0	87.5
Нэхмэлийн үйлдвэрлэлт	188622.6	226866.1	120.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1667.2	2544.1	152.6
Арьс шир боловсруулах үйлдвэр	6322.9	9682.0	153.1
Мод, модон эдлэл	2229.6	5006.1	224.5
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3527.2	6679.7	189.4
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	4465.0	5393.0	120.8
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	28406.6	46624.4	164.1
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	6464.1	6001.4	92.8
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2789.6	6354.8	227.8
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	77.3	188.2	243.5
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	13.8	259.5	18.0*
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	885.2	961.1	108.6
Мебель тавилга үйлдвэрлэл	204.4	282.3	138.1
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	73038.9	76890.4	105.3
ДҮН	592708.8	654462.9	110.4


*-дахин

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр
/оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016 он I-IX сар	2017 он I-IX сар	$\frac{2017}{2016} \%$	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	13805.7	15384.7	111.4	0.1
Төмрийн хүдэр олборлолт	13208.5	14580.7	110.4	-
Бусад ашигт малтмал олборлолт	597.2	804.0	134.6	100.0
Боловсруулах үйлдвэр	425413.3	518505.3	121.9	21.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	214581.7	248210.1	115.7	0.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	4515.7	1452.9	32.2	46.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2069.5	12975.2	6.3	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	18227.3	24076.3	132.1	
Ундаа үйлдвэрлэл	189769.2	209705.7	110.5	0.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	150136.9	177318.0	118.1	57.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1542.7	2526.3	163.8	
Арьс шир боловсруулах үйлдвэр	6382.5	9704.5	152.0	84.3
Мод, модон эдлэл	2229.6	5006.1	224.5	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3523.8	6679.7	189.6	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	5875.9	5706.4	97.1	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30715.9	49313.7	160.5	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	6464.1	6147.0	95.1	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2797.9	5972.6	213.5	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	75.9	188.2	248.0	
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	54.2	259.5	4.8*	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	828.0	1190.8	143.8	
Мебель тавилга үйлдвэрлэл	204.4	282.3	138.1	
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	73038.9	76890.4	105.3	
ДҮН	512258.0	610780.4	119.2	18.5

*-дахин

Зураг 10. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төг



Зураг 11. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төг



Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 497.6 тэрбум төгрөгийг дотоодод, 113.2 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 18.5 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 90.7 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 7.2 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 0.7 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг бусад ашигт малтмал олборлолт тус тус эзэлж байна.



хөдөө аж ахуй

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард 11062 хээлтэгч мал төллөжээ. Нийт төллөсөн 11069 төлийн 213 нь хорогдож, 10856 төл бойжиж байна. Төл бойжилт 98.0 хувьтай байна.

Хүснэгт 11. Төл бойжилт, төрлөөр, жил бүрийн эхний 9-р сард


Үзүүлэлт	2016.09	2017.09	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	15664	11062	-	776	3241	3746	3299
Гарсан төл	15688	11069	-	776	3241	3748	3304
Үүнээс: Хорогдсон төл	208	213	-	49	44	53	67
Бойжсон төл	15480	10856	-	727	3197	3695	3237
Бойжилтын хувь	98.6	98.0	-	93.7	98.6	98.6	97.9

Бойжсон нийт төлийн 6.7 хувийг унага, 29.4 хувийг тугал, 34.0 хувийг хурга, 29.9 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 12. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн эхний 9-р сард

Үзүүлэлт	2016.09	2017.09	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	376	706	-	80	141	259	226
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	13	24	-	3	17	2	2
Хорогдсон хээлтэгч	14	218	-	12	34	88	84

Зураг 12. Том малын зүй бус хорогдол, төрлөөр





БАРИЛГА

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 2017 оны 3-р улирлын байдлаар нийт 279.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 86 барилга, байгууламжийг барьж байна. Эдгээр барилга байгууламжийн 24.4 хувь нь төрийн, 75.6 хувь нь иргэний болон хувийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Мөн баригдаж буй объектуудыг давхарын хувьд бүлэглэн авч үзвэл 1-5 давхар 22.1 хувь, 6-10 давхар 22.1 хувь, 11-ээс дээш давхар 54.5 хувийг эзэлж байна.

Нийт гүйцэтгэлийн 98.8 хувийг шинэ барилга, өргөтгөлийн ажил, 1.2 хувийг их засварын ажил эзэлж байна. Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн 32.6 хувийг орон сууцны барилга байгууламжийн ажил эзэлж байна.



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн тохижилт үйлчилгээний төв 2017 оны 3-р улиралд хог цэвэрлэгээний ажлаар 826.3 мян.м² зам талбайг цэвэрлэж, нийт 48.2 мян.тн хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн нийт хогны 26.9 хувийг орон сууцнаас, 38.3 хувийг гэр хорооллоос, 27.9 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 6.9 хувийг зам талбайгаас тээвэрлэсэн хог эзэлж байна.

Энэ оны эхний 9 сард дүүргийн хог цэвэрлэгээний ажилд зарцуулсан хөрөнгийн 413.2 сая төгрөгийг зам талбай цэвэрлэсэнд, 1.9 тэрбум төгрөгийг хог тээвэрлэхэд зарцуулжээ.

Хүснэгт 13. Хог цэвэрлэгээний ажил, зарцуулсан хөрөнгө, 2017 оны 3-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Зарцуулсан хөрөнгө сая. төг	
		2016.III	2017.III	2016.III	2017.III
Цэвэрлэсэн зам талбай	мян м ²	773.9	826.3	299.9	413.2
Тээвэрлэсэн хог	тн	42248.3	48150.3	1651.6	1924.0
Үүнээс: Орон сууцнаас	тн	8955.3	12946.8	330.3	517.2
Гэр	тн	20917.3	18449.7	828.1	737.3
ААНБ-аас	тн	10588.8	13431.3	421.9	536.7
Зам	тн	1786.9	3322.5	71.3	132.6



МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2017 оны 3-р улиралд 63.2 сая төгрөг болсон байна. 3-р улиралд интернэтийн үйлчилгээг байнгын хэрэглэгч 50 хүн, интернэт үйлчилгээний цэгээр 460 хүн үйлчлүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 58.3 хувиар буурсан нь шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 14. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт, 3-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Нийт орлого	мян.төг	151690.2	63200.0
Үүнээс: Хүн амаас орсон орлого	мян.төг	151690.2	63200.0
Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо	хүн	512	460
Интернэтийн байнгын хэрэглэгч	хүн	55	50



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2017 оны 3-р улиралд давхардсан тоогоор 1206.4 мянган хүн тээвэрлэж, 635.2 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үеэс үйлчилгээний орлого 35.9 хувиар буюу 355.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 15. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, 3-р улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Нийт орлого	сая.төгрөг	990.9	635.2
Тээвэрлэсэн ачаа	мян.тн	1.0	1.0
Ачаа эргэлт	мян.т.км	43.2	392.0
Зорчигчдын тоо	мян.хүн	1572.2	1206.4
Зорчигч эргэлт	мян.хүн.км	5345.0	4100.6

Тээврийн салбарын 3-р улирлын орлогын бууралтад ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа түр зогссон нь нөлөөлжээ.



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 9 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 14.7 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 3.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжинд тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 61.0 хувийг нийгмийн халамжийн санд буюу нийт 15891 хүнд, 7521 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 273 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 7191 хүнд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, оны эхний 9 сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	10779.6	
1.Нийслэлийн төсвийн санхүүжилтийн орлого	8317.0	
а) Нийгмийн халамжийн сан	6444.3	
б) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1589.3	
в) ОНОТХаламжийн үйлчилгээ	86.8	
г) хүнс тэжээл хөтөлбөр	196.6	
2. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	2452.4	
а) алдарт эхийн одонгийн тусламж	1005.0	
б) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	385.0	
В) насны хишиг	1062.4	
3. Үйлчилгээний орлого	10.2	
а) хүүгийн орлого	8.0	
б) маягтын орлого		
в) бусад орлого	2.2	
Зарлагын нийт дүн	10769.4	37824
1. Нийгмийн халамжийн сан	6569.0	15891
2. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн	1554.6	7191
3. Алдарт эхийн одонгийн тусламж	982.7	7521
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	382.7	273
5. Хүнс тэжээл хөтөлбөр	199.1	393
6. ОНОТХ Үйлчилгээний зардал	27.1	70
7. Насны хишиг	1054.2	6485



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эхний 9 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 3037 байгууллагын нийт 127.0 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 61.1 мянга буюу 48.1 хувь нь ААНБ-ын, 10.6 мянга буюу 8.3 хувь нь төсвийн байгууллагын, 9.2 мянга буюу 7.3 хувь нь сайн дурын даатгуулагчид, 46.1 мянга буюу 36.3 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 17. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2016.09	2017.09	Өсөлт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	2850	3037	187	106.6
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	2734	2916	182	106.7
Төсөвт байгууллагын тоо	116	121	5	104.3
Нийт даатгуулагчдын тоо	107108	127022	19914	118.6
ААНБ-ын даатгуулагчийн тоо	53316	61074	7758	114.6
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	9834	10585	751	107.6
Сайн дурын даатгуулагчийн тоо	8464	9219	755	108.9
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	35494	46144	10650	130.0

2017 оны эхний 9 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 100.3 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 19.8 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн буюу 24.6 хувиар давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 18. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, оны эхний 9 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2016.09	2017.09	2016.09	2017.09	2016	2017
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	47518.6	51204.0	51488.8	63439.0	108.4	123.9
Тэтгэмжийн сангийн орлого	5370.6	6347.3	5837.4	8133.1	108.7	128.1
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	5568.6	5286.4	6842.8	7564.3	122.9	143.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1283.0	1404.7	1376.0	1661.9	107.2	118.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	15032.1	16293.6	15383.2	19539.3	102.3	119.9
Нийт	74722.9	80536.0	80928.2	100337.6	108.2	124.6


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.2 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.1 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.5 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.7 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 19.5 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 13. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 14. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 13276 хүнд 42.5 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2911 хүнд 6.2 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 799 хүнд 1.7 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1030 хүнд 5.0 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 8622 хүнд 1228.7 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 3043 хүнд 4.3 тэрбум төгрөгийг, 41 хүнд оршуулгын тэтгэмж 41.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 168 хүнд 662.4 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 18 хүнд 52.9 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 77 хүнд 51.2 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувилалд 24 хүнд 3.5 сая төгрөгийн тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1439 хүнд 2.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 63.7 хувийг тэтгэврийн, 7.8 хувийг тэтгэмжийн, 7.6 хувийг ҮОМШӨ-ний, 2.8 хувийг ажилгүйдлийн 18.1 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 15. Даатгалын сангийн орлого, зарлага сая.төг



Зураг 16. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2017 оны 9-р сарын байдлаар 555 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 415 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 58.4 хувь нь эмэгтэйчүүд байна.


2017 оны 9-р сард орон тооны цомхтголоор 45, байгууллага татан буугдсанаас 14, өөр газраас шилжиж ирсэн 18, сургууль төгссөн 20, цэргээс халагдсан 3, мэргэжлийн ажил олдохгүй 24, цалин багатайгаас 36, бусад шалтгаанаар 102 хүн ажилгүй болжээ.

Тайлант сард 70 хүн ажилд орсноос төрийн төсөвт байгууллагад 1, нөхөрлөл компанид 68, бусад байгууллагад 1 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 19. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн 9-р сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015.09	2016.09	2017.09	2015.09	2016.09	2017.09
Нийт ажилгүйчүүд	1512	970	555	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	747	617	290	49.4	63.6	52.3
Тусгай дунд боловсролтой	75	50	23	5.0	5.2	4.1
Мэргэжлийн анхан шатны	71	29	11	4.7	3.0	2.0
Бүрэн дунд боловсролтой	561	262	220	37.1	27.0	39.6
Бүрэн бус дунд	45	8	6	3.0	0.8	1.1
Бага, боловсролгүй	13	4	5	0.8	0.4	0.9

Зураг 17. Ажилгүйчүүд насны бүлгээр, 9-р сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 40.0 хувь буюу 222 нь анх удаа ажил хайж байгаа бол 60.0 хувь буюу 333 нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 8.5 хувь буюу 47 нь 16-24 насны, 47.2 хувь буюу 262 нь 25-34 насны, 26.8 хувь буюу 174 нь 35-44 насны, 17.5 хувь буюу 97 нь 45-60 насны хүмүүс байна.




ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард нийт 1875 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 34.9 хувиар буюу 1005 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 78.3 продицимилээр тус тус буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 26.9 хувийг салхин цэцэг, 9.2 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.4 хувийг тэмбүү, 20.1 хувийг гар хөл амны өвчин, 3.6 хувийг трихомониаз, 14.3 хувийг цусан суулга, 1.6 хувийг заг хүйтэн, 1.0 хувийг вируст гепатит, 0.7 хувийг гахайн хавдар, 18.2 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Зураг 18. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 19. Халдварт өвчнөөр өвчлөгчид



Хүснэгт 20. Эх, хүүхдийн эндэгдэл, жилийн бүрийн 9 сард

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	$\frac{2017}{2016} \%$
Амаржсан эхийн тоо	3315	3414	3219	-5.7
Амьд төрсөн хүүхэд	3329	3428	3243	-5.4
Төрөхийн улмаас эндсэн эх	1	2	1	-50
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	35	31	40	29.0
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	5	8	6	-25.0

2017 оны 9 сард төрөхийн улмаас эндсэн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 1 эхээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 хүүхдээр буурч, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 9-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 21. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн 9 сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	2880 199.1	1875 120.8	-1005 -78.3	-34.9
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	19 1.3	18 1.2	-1 -0.1	-5.3
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	194 13.4	269 17.3	75 3.9	38.6
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	74 5.1	154 9.9	80 4.8	1.8 дах
Сальмонеллёз	Бодит тоо 10000 хүнд	15 1.0	12 0.8	-3 -0.2	-20
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	291 20.1	505 32.5	214 12.4	73.5
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	16 1.1	13 0.8	-3 -0.3	-18.75
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	10 0.7	9 0.6	-1 -0.1	-10
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	413 28.6	377 24.3	-36 -4.3	-8.71
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	95 6.6	82 5.3	-13 -1.3	-13.6
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	30 2.0	31 2.0	1 -	3.3
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	80 5.5	67 4.3	-13 -1.2	-16.2
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	222 15.3	172 11.1	-50 -4.2	-22.5
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	9 0.6	3 0.2	-6 -0.4	-66.6
Улаан бурхан	Бодит тоо 10000 хүнд	1366 94.4	1 0.1	-1365 -94.3	-99.9
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	46 3.2	162 10.5	116 7.3	2.5 дах



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард 1275 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиар буюу 4 хэргээр өсчээ.

Зураг 20. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо




Нийт гэмт хэргийн 33.7 хувь буюу 430 нь хулгайн хэрэг, 25.7 хувь буюу 327 нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 9.6 хувь буюу 122 хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 3.8 хувь буюу 48 хэрэг нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэрэг, 3.1 хувь буюу 39 нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 0.9 хувь буюу 12 нь хүчингийн хэрэг, 2.0 хувь буюу 26 нь дээрэмдэх хэрэг, 6.2 хувь буюу 79 нь ХАБТХАЖЭ хэрэг, 0.2 хувь буюу 3 нь хүнийг алах хэрэг, 0.5 хувь буюу 6 нь малын хулгайн хэрэг, 14.3 хувь буюу 183 нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 22. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2016.9	2017.9	$\frac{2017}{2016} \%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	20	39	95.0	19
Хүчин	10	12	20.0	2
Дээрэм	21	26	23.8	5
Хулгай	353	430	21.8	77
Залилан мэхлэх	140	122	-12.9	-18
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	409	327	-20.0	-82
Малын хулгай	8	6	-25.0	-2
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	70	48	-31.4	-22
Хүнийг санаатай алах	4	3	-25.0	-1
ХАБТХАЖЭ*	73	79	8.2	6
Бусад	163	183	12.3	20
БҮГД	1271	1275	0.3	4

Нийт хулгайн хэрэг 430 байгаагаас 92.1 хувь нь иргэний өмчийн хулгай, 5.1 хувь нь халаасны хулгай, 0.7 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг байна.

Зураг 21. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 23. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ	Бусад
	2016.IX сар	2017.IX сар	Тоо	%						ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1	72	64	-8	-11.1	1	13		1	13	9		2	10	13		2	4	5
2	150	128	-22	-14.7	2	29			41	37	2	1	4	18		6	8	20
3	155	143	-12	-7.7	3	39		1	33	29	1	1	2	13		7	13	32
4	98	108	10	10.2	1	3	23	1	52	43		8	1	6	1	2	6	12
5	28	27	-1	-3.6	2	6		1	10	9		1				1	1	6
6	19	35	16	84.2	1	13	1	1	11	11						2	2	5
7	26	27	1	3.8	2	7			11	11			1			2	1	3
8	50	58	8	16.0	5	18	2		25	24					1	2	2	5
9	48	44	-4	-8.3	5	11	1	1	13	13				1		4	3	5
10	110	117	7	6.4	4	36			31	30				7		6	13	20
11	143	153	10	7.0	4	39	4	1	61	56		5		25			4	19
12	37	52	15	40.5	3	14			24	24				2	2	2	2	4
13	21	35	14	66.7	2	9		3	12	12			1		2		4	2
14	41	41	0	0.0	1	5		2	19	18			2	2		1	5	4
15	203	179	-24	-11.8	2		47		48	45		3	5	28		9	9	31
16	70	64	-6	-8.6	1	18	1		26	25		1	1	6		2	2	8
ДҮН	1271	1275	4	0.3	3	39	327	9	12	430	396	3	22	26	122	6	48	183

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны эхний 9 сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 2529 өргөдөл, гомдол ирсний 1523-ыг нь хуулийн дагуу хугацаанд нь хариу өгч ажиллажээ. Шийдвэрлэх хугацаа болоогүй 997 өргөдөл байна.

Хүснэгт 24. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
ТЗУХ	307	284			23	13	294				303		4	
СТСХ	1				1	1					1			
ТГХШХ	8	8					8				8			
НХХ	38	34			4	5	33				37		1	
ТНААХ	155	92			63	57	1		97		147		8	
ХХҮХ	52	43			9	10	1		41		49		3	
Цэргийн штаб	58	58			0		58				58			
Хууль зүйн тасаг	34	32			2	8		1	25		34			
ЗДТГ-ын дүн	653	-	551	-	102	94	2	1	556	-	637	-	16	-
ХХ	0													
ХХҮХ	167	164			3	2	165				167			
Газрын алба	1133	1011			122		1133				153		980	
БоХ	125	55			64	52	12	6	55	9	115		1	
ОБХ	0													
Албан бус- НТБ төв	412	412	-				412				412			
БХ	39	39					39				39			
Дэргэдэх хэлтэс албадын дүн	1876	412	1681	6	189	54	12	6	1804	-	886	-	981	-
ДҮН	2529	412	1820	6	291	148	14	7	2360	9	1523	-	997	-

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: мэргэжилтэн Г.Энхцэцэг

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
1212.mn



Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МонСтат аппликейшн



Download on the
App Store

Google play



Утсаар:



Лавлах утас
1900-1212

QR код уншуулж татаж авна уу.

